

## МУИС, ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БИЧИГ №7(159), 2000

### **14.5МэВ ЭНЕРГИТЭЙ НЕЙТРОНООР ЯВАГДАХ (n,p) БА (n, α) УРВАЛУУДЫН ОГТЛОЛЫН СИСТЕМАТИК ЗҮЙ ТОГТОЛ ДАХЬ ЗАРИМ ОНЦЛОГ**

Б.Отгоолой , И.Чадраабал  
МУИС, Цөмийн судалгааны төв

*Түлхүүр үг: (n,p), (n, α) урвал, огтлол, параметр, изотоп, цөмийн цэнэг, илүүдэл нейтроны тоо*

**Товч утга:** Урвалын огтлолын утгуудад системчилсэн боловсруулалт хийж  $Z > 18$  тохиолдолд С, К параметрүүд (n,p) урвалын үед элементүүдийн хамгийн хөнгөн, тогтвортой изотопуудын илүүдэл нейтроны болон масс тооцуудаас , харин (n, α) урвалын огтлол зөвхөн  $(N-Z)/A$  харьцаанаас хамаарна гэдгийг харуулав.

#### **Оршил**

14.5 МэВ энергитэй нейтроноор явагдах (n,p) ба (n, α) урвалын огтлолыг дараах хэлбэртэйгээр тодорхойлсон байдаг [1,2].

$$\sigma_{n,\alpha} = 0.4 \sigma_{n,p} \quad (1)$$

$$\sigma_{n,p} = C \pi r^2 (A^{1/3} + 1)^2 e^{-K(N-Z)/A} \quad (2)$$

Энд:  $\sigma_{n,\alpha}$  ,  $\sigma_{n,p}$ -нейтроноор явагдах (n,α), (n,p) урвалын огтлол

$A, Z, N$  – тухайн цөмийн масс, цэнэгийн болон нейтроны тоо

$r$ - цөмийн радиусын тогтмол буюу 1.2-1.4 ферми

Өөрөөр хэлбэл эдгээр урвалуудын явагдах механизмыг ижилхэн бөгөөд параметрүүдийг элементүүдийн хувьд тогтмол  $C=45.2$ ;  $K=33$  гэж таамагласан байдаг.

---

"Нейтрон" төслийн дагуу гүйцэтгэв

Энэхүү ажлын гол зорилго нь дээрх таамаглалыг шалгахад оршино.

### 1. Мэдээллийн санг бүрдүүлсэн байдал


Судалгааны эцсийн дүгнэлтийн үнэмшилийн түвшин нь ашиглагдаж байгаа туршлагын мэдээллийн санг бүрдүүлсэн байдлаар шууд тодорхойлогдоно.

Иймд бид дэлхийн янз бүрийн лабораториудад хэмжигдэж "NUCLEAR PHYSICS" сэтгүүлд 1963 оноос хойш, ОУАЭА-аас эрхлэн гаргадаг Нейтроны мэдээлэл"-ийн санд харьцангуй үнэмшилтэй гэгдэн бүртгэгдэж INDC сэтгүүлийн 1989-1998 оны дугааруудад болон бусад ажилд [3] хэвлэгдсэн туршлагын утгуудыг сонгон авсан.


Харьцангуй үнэмшилтэй гэгдсэн энэхүү хэмжилтийн утгууд болон бусад лабораториудад зэрэгцээ хэмжигдсэн утгууд өөр хоорондоо алдааныхаа мужид тохиорхгүйгээр үл барам хэд дахин зөрүүтэй ч байх тохиолдол байсан нь сонгогдсон утгуудын алдааг тодорхойгүй болгоход хүргэсэн билээ. Иймд бид статистик боловсруулалт хийхэд тухайн утгуудын алдааг тооцоогүй болно.

### 2.( $n, \alpha$ ) урвалын тохиолдолд:


Мэдээллийн санг ашиглан элементүүдийн хувьд тодорхойлгдсон  $K_n$ ,  $\ln(\pi r^2 C_n)$  параметрүүдийн утга цөмийн цэнэгийн тооноос хэрхэн хамаарахыг 1 ба 2-р зургуудад үзүүлэв.



Зураг 1. К параметр цөмийн цэнэгийн тооноос хамаарал



Зураг 2.  $\ln(\pi r^2 C)$  параметр цөмийн цэнэгийн тооноос хамаарал Зургуудаас харахад  $Z > 18$  тохиолдолд тухайн параметруүд цөмийн цэнэгээс үл хамааран тогтмол гэж үзэж болно. Байдлыг ойлгомжтой болгох үүднээс бүх 180 хэмжилтийн утгуудын систематик зүй тогтлыг 3-р зурагт үзүүлэв.




Зураг 3. 14.5 МэВ энергитэй нейтроноор явагдах ( $n, \alpha$ ) урвалын отплол  $(N-Z)/A$ -аас хамаарах ерөнхий зүй тогтол

Хар гурвалжингаар  $Z < 18$  байх элементүүдэд харгалзах хэмжилтийн утгууд тэмдэглэгдсэн бөгөөд зурагт үзүүлсэн ерөнхий статистик зүй тогтолд ихэнх нь хамарагдахгүй болох нь харагдаж байна.

Зурагт заагдсан чагтан тэмдэгүүд нь тухайн элементийн изотопуудын хувьд  $\sigma_{n,\alpha} = C_\alpha \pi r^2 (A^{1/3} + 1)^2 \exp[-K_\alpha (N-Z)/A]$  хамаарлаас хэт гажсан цэгүүдийн утгуудад харгалзаж байгаа.

Тухайлбал Sn элементийн 9 изотопын нэгд нь харгалзах утга бусдаасаа онцгой үсэрснийг жишээ болгон 4-р зурагт зүүлэв.



Зураг 4. Sn – элементийн изотопууд дээр явагдах ( $n,\alpha$ ) урвалын огтлол  $(N-Z)/A$  –аас хамаарал.  $x - Sn_{50}^{118}$

Энэхүү жишээнээс үзэхэд чагтан тэмдэгүүдэд харгалзах хэмжилтийн утгуудыг үнэмшил багатай гэж үзэх бүрэн үндэслэлтэй. Нэг шулууны дагуу нягтарсан бусад цэгүүдээр бодогдсон  $K_\alpha = 33.119$ ,  $\ln(\pi r^2 C_\alpha) = 2.871$  утгууд өмнө тодорхойлогдсонтойгоо /1 ба 2-р зургуудыг үз/ сайн дүйж байгаа нь цөмийн цэнэгийн дурьдагдсан мужид  $K_\alpha$ ,  $C_\alpha$  параметруүдийг тогтмол гэдгийг харуулж байна.

Өөрөөр хэлбэл 14.5МэВ энергитэй нейтроноор явагдах ( $n,\alpha$ ) урвалын огтлолыг үнэлэхэд дараах томьёог ашиглах бүрэн бололцоотой.


$$\sigma_{n,\alpha} = 0.39\pi r^2 (A^{1/3}+1)^2 e^{-33.12(N-Z)/A}; \quad Z > 18 \quad (3)$$

Энд тэмдэглэхэд:


- $r = 1.2$  ферми (1.4 ферми тохиолдолд  $C_\alpha = 0.287$  болно.) Өөрөөр хэлбэл  $C_\alpha$ -ийн утга  $r$  хэмжигдэхүүнд ямар утга орлуулснаас хамаарах учраас  $\ln(\pi r^2 C_\alpha)$ -ийг тодорхойлсон болно.
- $Ar_{18}^{40}$  изотопод харгалзсан хэмжилтийн утга томьёо (3)-д таарч байгаа боловч бусад изотопынх нь хэмжилт олдоогүй тул  $Z$ -ийн аль ч мужид харьялаулаагүй.

### 3. (n,p) урвалын тохиолдолд: $Z \geq 18$


Хэмжилтийн утгуудыг ашиглан томьёо (2)-ын тусламжтайгаар  $\ln(C\pi r^2)$  ба K параметрийг элементүүдийн хувьд тодорхойлж, цөмийн цэнэгийн тооноос хамаарлыг нь хамгийн хөнгөн тогтвортой изотопуудын илүүдэл нейтроны  $N_{min}$  тоотой жишиж 5-р зурагт үзүүлэв. Тодорхойлогдсон параметрүүдийн утгууд тогтмол биш бөгөөд тодорхой муж дахь Z-ээс хамаарлууд нь  $N_{min}$ -ийнхтэй төсөөтэй байгаа нь зургаас харагдаж байна.



Зураг 5. К,  $\ln(C\pi r^2)$  параметрүүд болон  $N_{min}$  цөмийн цэнэгээс хамаарал



Зураг 6. К параметр  $N_{min}/A_{min}$  -аас хамаарал



Зураг 7.  $\ln(C\pi r^2)$  ба  $N_{\min}/A_{\min}$  хоёрын хамаарал

Иймээс энэ ажилд С, К параметрүүд нь тухайн элементийн хамгийн хөнгөн тогтвортой изотопод харгалзах масс тоо  $A_{\min}$  илүүдэл нейтроны  $N_{\min}$  тоонуудаар тодорхойлогдоно гэж үзээшалгасан байдлыг 6 ба 7-р зургуудад үзүүлэв.

Зургуудаас харахад К ба  $\ln(C\pi r^2)$ -ийн утгууд  $N_{\min}/A_{\min}$  харьцаана шугаман хамааралтайгаар ерөнхийдөө хоёр өөр өөр шулуун дээрээмбэлэгджээ.

Тухайлбал цөмийн цэнэгийн тоо  $Z < 58$  байх элементүүд харгалзах параметрүүд нэг шулуун дээр бусад үлдсэн  $57 < Z$  бүх хүнд элементүүдийнх нөгөө шулуун дээр тус тус эрэмбэлэгдсэн байна.

### Хэлэлцлэг

Бидний хийсэн судалгааны дүнгээс үзэхэд  $Z > 18$  тохиолдолдо (п.и.) урвалын үед С., К. параметрүүд тогтмол [1] гэдэг харагдав.

Харин (п.р) урвалын тохиолдолд С,К параметрүүд тогтмол бишэ барахгүй цөмийн цэнэгийн тодорхой мужид өөр өөр хамааралт байгаа нь (п.и) ба (п.р) урвалуудын огтполуудын хувьд тэнцэтгэл (биелэхгүй гэсэн дүгнэлтэнд хүргэж байна.

Өөрөөр хэлбэл дээрх урвалууд ижилхэн механизмаар явагда гэдэг дүгнэлт ч эргэлзээтэй.

Тухайн авч үзэж байгаа урвалуудын явагдах механизму ондоо гэж үзвэл, (п.и) урвалын үед С., К. параметрүүд тогтмол байгаагаас харахад, тодорхой  $Z$ -ээс эхлэн цөмийн кластер бүтэцтэй байгаа альфа бөөмийн хувьд кулоны потенциалаас өөр төвөгтэй саад байхгүй байх талтай.

байгаа альфа бөөмийн хувьд кулоны потенциалаас өөр төвөгтэй саад байхгүй байх талтай.

Хэрэв дээрх таамаглал үнэн гэвэл протоны гарах магадлал нь, альфа бөөмийнхтэй харьцангуй ~2.5 дахин их байдаг нь кулоны потенциалтай холбоотой боловч, цөм болон  $\alpha$  бөөмсийн харилцан оршин тогтнож буй шүтэлцээнээс шалтгаалах нь гарцаагүй.

Бидний энэхүү төсөөлөл нь дээрх зөрчлийг тайлбарлах олон хувилбаруудын нэг бөгөөд өнгөцхөн хараад судалгааны ҮР дүнтэй тийм ч их зөрчилдөхгүй байгаа боловч зерэг болон сөрөг талаас нь батлахад тун ярвигтай.

Нөгөө талаас энэхүү ажилд хөндөгдсөн систематик боловсруулалт болон хэрэглэгдсэн арга нь тухайн тохиолдол учраас цаашид давхар хувьсагчтай функцэд шинжилгээ хийдэг программын тусламжтайгаар янз бүрийн хувилбараар шалгах шаардлагатай.

## Дүгнэлт

1. Хурдан нейтреноор явагдах ( $n,p$ ) урвалын үед элементуудийн хамгийн бага масс бүхий тогтвортой изотопуудад харгалзах ( $N-Z/A$ ) харьцаагаар С, К параметрүүдийг тодорхойлж болно.
2. Цөмийн цэнэгийн тоо нь 18-аас дээш тохиолдолд ( $n,\alpha$ ) урвалын үед С $_{\alpha}$ , К $_{\alpha}$  параметрүүд тогтмол байна.
3. Харин цэнэгийн тоо 19-өөс бага элементүүд дээр явагдах тухайн урвалуудын огтололын туршлагын найдвартай мэдээллүүдийг цуглуулж, судалгаа хийх шаардлагатай.

### Ашигласан ном

#### 1. В.Н.Левковский

Сечения реакций ( $n,p$ ) и ( $n,a$ ) при энергии нейтронов 14-15 МэВ  
ЯФ, 18(1973) №4, 705-709

#### 2. В.Н.Левковский

Эмпирические закономерности в сечениях реакций ( $n,p$ ) при энергии нейтронов 14-15 МэВ ЖЭТФ, Т.45 (1963) вып.2 (8), 305-311

#### 3. С.А.Бадиков, А.Б.Пашенко

Сравнительный анализ систематик сечений реакции ( $n,p$ ) при энергии нейтронов 14-15 МэВ ФЭИ-2055 Обнинск-1989

**Резюме.** На основе систематической обработки существующих экспериментальных результатов показано, что при  $Z > 18$  сечения реакций ( $n,\alpha$ ) зависят только от  $(N-Z)/A$ , а для реакций ( $n,p$ ) параметры С и К зависят от избытка нейтронов и массового числа самых легких стабильных изотопов .